

2021

Монгол Улсын 2021
оны эхний хагас
жилийн эдийн засаг,
төсвийн тойм

*Монгол Улсын Сангийн яам төсвийн чиглэлээр олон нийтэд
хүрэх мэдээллийг өргөжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор
ХАГАС ЖИЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ТОЙМЫГ
боловсруулан хүргэж эхэллээ.*

Агуулга

Макро эдийн засгийн 2021 оны эхний хагас жилийн тойм.....	3
Нэгдсэн төсвийн 2021 оны эхний хагас жилийн тойм.....	6
Төсвийн орлого	7
Төсвийн зарлага	8
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	8
Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	8
Засгийн газрын өр.....	10
ХАВСРАЛТ 1. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд.....	11
ХАВСРАЛТ 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (эдийн засгийн ангиллаар, тэрбум төгрөг).....	12
ХАВСРАЛТ 3. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хагас жилийн гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэл (төсвийн ерөнхийлөн захирагчаар, сая төгрөг).....	13
ХАВСРАЛТ 4. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)	14

Макро эдийн засгийн 2021 оны эхний хагас жилийн тойм

Эдийн засгийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлт

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2021 оны эхний улиралд 9.2 их наяд төгрөгт хүрч (оны үнээр тооцсон), эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар өссөн байна.¹

Энэхүү өсөлт нь Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд вакцинжуулалтыг шуурхай

эхлүүлсэн, өрхийн орлогыг хамгаалахад чиглэсэн нийгмийн халамжийг үргэлжлүүлсэн, ААН-үүдэд зээл олгож ажлын байрыг хадгалсантай холбоотой байна.

Нүүрсний экспорт эхний улиралд өнгөрсөн оны мөн үеэс 113.7 хувиар өссөн бол Оюутолгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж нэмэгдсэн, дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлттэй холбоотойгоор зэсийн баяжмалын экспорт нэмэгдэж байна.


Цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн сэргэлт удаашралтай байгаа тул Засгийн газраас иргэдийн орлогыг хамгаалах, ААН-үүдийг дэмжих, нийгмийн хамгааллын бодлогоо эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлж байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар

	2018	2019	2020	2021
	Жил бүрийн эхний улирал			
Эдийн засгийн өсөлт	6.2	8.6	-10.7	15.7
Хөдөө аж ахуй	3.7	2.1	14.0	-6.6
Үйлдвэрлэл	5.6	12.0	-19.6	26.6
Уул уурхай	3.8	14.4	-29.5	34.1
Боловсруулах аж үйлдвэр	7.9	7.3	5.1	21.0
Цахилгаан	9.6	3.7	6.8	7.6
Барилга	27.2	7.3	12.0	-6.4
Үйлчилгээ	4.4	7.6	-6.8	3.6
Худалдаа	6.0	15.1	-11.1	6.3
Тээвэр	0.1	3.4	-30.6	5.6
Мэдээлэл, холбоо	6.4	10.7	0.3	3.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	4.7	5.2	0.7	2.2
Цэвэр татвар	16.4	5.5	-7.9	45.3

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн хороо

Зураг 1. Эдийн засгийн өсөлт, хувь




Эх үүсвэр: Үндэсний Статистикийн хороо

¹ (2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг 2021 оны 8 дугаар сард ҮСХ-оос гаргана.)

Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний хагас жилд 7.4 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 39.4 хувиар өссөн нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эдийн засагт үзүүлсэн огцом шокийн нөлөө аажмаар буурч байгааг харуулж байна. Экспорт өмнөх оны мөн үеэс 45.4 хувиар өсөж 4.1 тэрбум ам.долларт, импорт өмнөх оны мөн үеэс 32.6 хувиар өсөж 3.3 тэрбум ам.долларт тус тус хүрснээр гадаад худалдааны тэнцэл 850.2 сая ам.долларын ашигтай гарлаа.

Зураг 2. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт, импорт, тэнцэл, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар

Оюутолгой компанийн зэсийн баяжмал дахь алтны агууламж нэмэгдсэн, дэлхийн зах зээл дэх цэвэр зэсийн үнэ 64.9 хувиар өссөнтэй холбоотойгоор зэсийн баяжмалын экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 77.2 хувиар нэмэгдсэн байна. Нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.3 хувиар өссөн, нийт нүүрсний экспортод эзлэх коксжих нүүрсний экспортын хэмжээ нэмэгдсэн болон дэлхийн зах зээлийн үнэ өссөнөөр өмнөх оны мөн үеэс нүүрсний экспорт үнийн дүнгээрээ 47.3 хувиар өссөн байна.


Дэлхийн зах зээл дэх төмрийн хүдэр, газрын тосны үнэ өндөр байгаа бөгөөд манай улсын төмрийн хүдрийн экспорт 92.0 хувиар, харин боловсруулаагүй газрын тосны экспорт 395.7 хувиар өмнөх оны мөн үеэс өссөн байна.

Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс 152.8 хувиар өссөн. Үүнд угаасан ноолуур, хушны самар, лаазалсан махны экспортын өсөлт голлох нөлөөг үзүүлжээ. Дизель түлш, ачааны автомашин, чиргүүл болон тэдгээрийн эд ангийн импорт нэмэгдсэн нь импортын хэмжээ өсөхөд голлох нөлөөг үзүүлэв.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 54.2 сая ам. долларын алдагдалтай гарлаа. Экспортын орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор урсгал ба хөрөнгийн дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 50 хувиар буурсан байна. Урсгал ба хөрөнгийн данс 871.3 сая ам.долларын алдагдалтай гарсан бол санхүүгийн данс 768.6 сая ам.долларын ашигтай гарсан байна. Шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 1066.0 сая ам.доллар болж 13.2 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүлжээ.

Зураг 3. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар




Эх үүсвэр: Монголбанк

Инфляц

Инфляц 2021 оны 6 дугаар сарын байдлаар 6.6 хувийн өсөлттэй гарлаа. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр эдийн засаг дахь эрэлт саарсантай холбоотойгоор 2020 онд инфляц нам дор түвшинд хадгалагдаж байв. Харин шатахууны үнэ (суурь оны бууралтын нөлөө), сайжруулсан шахмал түлшний үнэ (өвлийн улиралд 75 хувиар бууруулсан байсан), мөн хүнсний бүлгийн үнэ өссөнтэй холбоотойгоор сүүлийн саруудад инфляцад богино хугацааны өсөлт ажиглагдлаа.

Зураг 4. Инфляцын бүтэц, хувь




Эх үүсвэр: Үндэсний Статистикийн хороо

Эдийн засгийн 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр 2020 онд огцом суларсан эдийн засгийн идэвхжил сэргэж эхэлсэн ч эдийн засаг потенциал түвшингээсээ доогуур хэвээр байна. Иймд

Зураг 5. Олон улсын байгууллагуудын төсөөлөл



Эх үүсвэр: ОУВС, ДБ, АХБ

Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн идэвхжилийг сайжруулах, ажлын байрыг хадгалахад чиглэсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Түүнчлэн хүүхдийн мөнгө олгох, өрхийн орлогыг хамгаалах, зээл төлөлтийг хойшлуулах зэрэг төсөв, мөнгөний тэлэх бодлогоор эдийн засгаа дэмжиж байгаагийн үр дүнд 2021 оны эцэст эдийн засгийн өсөлт 6.5 орчим хувьд хүрэхээр хүлээгдэж байна.

Олон улсын байгууллагууд Монгол Улсын эдийн засгийг 2021 онд 5-6 орчим хувиар өсөхөөр төсөөлсөн.

Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 14.5 тэрбум ам долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 1.9 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна. Экспортын хэмжээ 8.2 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна. Олон улсын банк, санхүүгийн байгууллагын

шинжээчдийн таамгаар 2021 оны сүүлийн хагаст нүүрс, газрын тос, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, алт зэрэг уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ тогтвортой байхаар хүлээгдэж байна.

Эдийн засгийн идэвхжил 2020 онтой харьцуулахад аажмаар сэргэж байгаатай холбоотойгоор өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт нэмэгдэх төлөвтэй. Иймд импортын хэмжээ 2021 оны эцэст 6.3 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна.

Төлбөрийн тэнцэл

2021 оны сүүлийн хагаст гадаад худалдааны тэнцлийн ашиг нэмэгдэхээр байгаа бол томоохон дүнтэй бонд, зээлийн эргэн төлөлттэй холбоотой валютын гадагшлах урсгал байхгүй байна. Иймд төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд дарамт бага, **төлбөрийн тэнцэл ашигтай гарахаар хүлээгдэж байна.**

Инфляц

Вакцинжуулалт амжилттай хийгдэж, эдийн засаг алгуур сэргэж байгаатай холбоотойгоор дэлхийн ихэнх орнуудад хүнсний бүлгийн үнэ өсөж байгаа хандлага манай улсад ч мөн ажиглагдаж байна. Нөгөө талаас дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ 2021 онд сэргэсэн нь дотоодын шатахуун, түлшний үнэ өсөх, импортын бараа бүтээгдэхүүний хилээр нэвтрүүлэлт удааширсан нь бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт доголдох зэрэгтэй холбоотойгоор үнэ өсөж болзошгүй.

Инфляц Монголбанкны зорилтот түвшин (6 хувь \pm 2 нэгж хувь)-д байна.

Инфляц Монголбанкны зорилтот түвшин (6 хувь \pm 2 нэгж хувь)-д байгаа бөгөөд удаан үргэлжилсэн инфляцын дарамт үүссэн тохиолдолд бодлогын тохируулга хийгдэх болно.

Нэгдсэн төсвийн 2021 оны эхний хагас жилийн тойм

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

	2020 Гүйц. (1)	2021 Тод. (2)	2021.06 Гүйц. (3)	2021 ХБГ* (4)
НИЙТ ОРЛОГО	10,444.2	13,731.7	7,106.1	13,731.7
Тогтворжуулалтын сан	66.2	612.8	259.7	612.8
Ирээдүйн өв сан	914.1	1,062.4	417.7	1,062.4
Тэнцвэржүүлсэн орлого (I)	9,463.8	12,056.4	6,428.7	12,056.4
НИЙТ ЗАРЛАГА (II)	13,904.3	15,748.3	7,498.2	15,495.5
Урсгал зарлага	10,828.9	12,983.7	6,559.6	12,983.7
Хөрөнгийн зарлага	3,034.2	3,363.5	859.6	3,110.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	41.1	(598.9)	78.9	(598.9)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ (I-II)	-4,440.5	-3,691.8	-1,069.5	-3,439.1
ДНБ-д эзлэх хувь	-12.0%	-8.8%		-8.2%

*Хүлээгдэж буй гүйцэтгэл

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг улс орнууд өөрсдийн эдийн засаг, төсөв санхүүгийн боломждоо тааруулан хэрэгжүүлж байна. Засгийн газрын зүгээс Монгол Улсад халдварын тархалт нэмэгдэж урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдал үүссэн тул эрүүл мэндийн салбарын нэн шаардлагатай зардлыг санхүүжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах зарим арга хэмжээг

үргэлжлүүлэх төсвийн тодотголыг 2021 оны 6 дугаар сарын 29-ий өдөр УИХ-д өргөн барьж, 7 дугаар сарын 7-ны өдөр УИХ хэлэлцэн баталлаа.

2021 оны эцсээр нийт орлого тодотголын түвшинд байхаар, харин нийт зарлага тодотголын түвшнээс 849.1 тэрбум төгрөгөөр буурсан гүйцэтгэлтэй байхаар хүлээгдэж байна. Ингэснээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,842.7 тэрбум буюу ДНБ-ий -6.8 хувьтай тэнцэхээр байна.

Төсвийн орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2021 оны эхний 6 сарын байдлаар 7,106.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 471.0 тэрбум төгрөгөөр давж биелжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,747.4 тэрбум төгрөг буюу 63.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл тодотголын түвшинд байхаар байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос харна уу.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар төсвийн орлогын гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс **63 хувиар** өссөн үзүүлэлттэй байна.

Уул уурхайн салбарын орлого

Энэ оны төсвийн тодотголд олон улсын зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг тонн тутамд 9,076 ам.доллар, нүүрсний үнийг тонн тутамд 75-125 ам.доллар байхаар, зэсийн баяжмалын экспортын хэмжээг 1,118.4 мянган тонн, нүүрсний экспортын биет хэмжээг 28.7 сая тоннд хүрнэ гэж тооцсон. Улмаар уул уурхайн салбараас нийт 3,515.6 тэрбум төгрөгийн орлого, үүнээс 47.5 хувь буюу 1,669.3 тэрбум төгрөгийн орлогыг зэсээс, 36.6 хувь буюу 1,287.8 тэрбум төгрөгийн орлогыг нүүрснээс, үлдэх 15.9 хувь буюу 558.5 тэрбум төгрөгийн орлогыг бусад ашигт малтмалаас бүрдүүлэхээр тооцсон.

Энэ оны 3 дугаар сарын сүүлээс эхлэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр нүүрсний экспортын гол боомтуудаар нэвтрэх машины тоо буурч, нүүрсний орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй байгаа боловч дэлхийн зах зээл дахь зэсийн үнийн өсөлтөөс нэмэгдэж байгаа орлогын дүнгээр уул уурхайн салбарын орлого тодотголын түвшинд хадгалагдахаар байна.

Зэсийн үнийн өсөлт

Өнгөрсөн оны сүүлийн хагасаас эхлэн дэлхийн зах зээл дахь зэсийн үнэ тогтмол нэмэгдэж байгаа бөгөөд үүнд БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт, Өмнөд Америкийн зэсийн томоохон уурхайнуудад ажил хаялт зарласан зэрэг нь голлох нөлөөг үзүүлжээ. Энэ оны эхний 6 сард зэсийн үнэ тонн тутамд дунджаар 9,094.6 ам.долларт хүрээд байгаа бөгөөд олон улсын банк санхүүгийн байгууллагуудын үзэж байгаагаар жилийн дундаж үнэ тонн тутамд 9,076 ам.доллар байх төлөвтэй байна.

Нүүрсний экспорт

Засгийн газраас ашигт малтмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд оны эхнээс эхлэн тээвэр хийж байгаа жолооч нарыг бүрэн вакцинжуулах, экспортын голлох боомтуудыг ногоон

бүсээр зарласны үр дүнд энэ оны эхний 6 сарын байдлаар нүүрсний экспортын биет хэмжээ 9.6 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 0.9 сая тонноор нэмэгдсэн байна.

Төсвийн зарлага

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Нийт зарлага ба цэвэр зээлийг 13,944.9 тэрбум төгрөгөөр баталсныг коронавируст халдварын тархалттай холбоотой цаг үеийн шаардлагаар 12.9 хувиар буюу 1,803.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 15,748.3 тэрбум төгрөг болгон тодотгосон. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 7,498.2 тэрбум төгрөг буюу 47.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардал болон эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ тодотголын түвшинд байхаар хүлээгдэж байна. Харин нийт хөрөнгийн зардал Улсын төсвийн хөрөнгийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэлийн бууралттай тэнцэх хэмжээгээр буурахаар байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос харна уу.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 1,418.9 тэрбум төгрөгийн 1101 төсөл, арга хэмжээ, концессийн “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 5 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 266.3 тэрбум төгрөг, нийт 1,685.2 тэрбум төгрөг батлагдсан. 2021 оны жилийн эцсийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт гүйцэтгэлийг өмнөх онуудын гүйцэтгэлээс багагүй байхаар буюу 1,432.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, гүйцэтгэл **85 хувь** байхаар тооцоолж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны гүйцэтгэл **85 хувьтай** байхаар хүлээгдэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний ихэнх нь улирлын чанартай барилгын ажил байдаг тул 2021 оны 1 дүгээр улирлын сүүлээр ихэнх бүтээн байгуулалтын ажил эхэлсэн. Түүнчлэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас шалтгаалсан барилгын материалын нийлүүлэлт, ажиллах хүчний хомсдол бий болсон нь хүлээгдэж буй гүйцэтгэлийн үзүүлэлтэд нөлөөлж байна. Дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас харна уу.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, амьжиргаа, орлогыг дэмжих, ажлын байрыг хадгалах, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, эдийн засгийн хүндрэлээс сэргийлж, эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч байна.

- ✓ **Түрээсийн төлбөрийн хэмжээг бууруулсан** 146 ААН, 3,368 бизнес эрхлэгчдэд 2020 онд нийт 2.3 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлтийг эдлүүлсэн.
- ✓ 145,199 татвар төлөгчийн хуульд заасан хугацаанд төлөөгүй 64.5 тэрбум төгрөгийн татварыг 2020 онд **татварын алданги, торгуулиас чөлөөлсөн.**

- ✓ Эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг импортолсон 226 ААН, 99 иргэний 14.3 тэрбум төгрөгийн татварыг 2020 онд гаалийн албан татвар болон НӨАТ-аас чөлөөлсөн.
- ✓ Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1 хүртэл үргэлжлүүлсэн бөгөөд энэхүү арга хэмжээнд 2021 оны эхний хагас жилд 724.5 тэрбум төгрөг зарцуулаад байна.
- ✓ Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр 288.0 мянган төгрөг олгоод байна. Тус арга хэмжээнд 68.1 мянган иргэн хамрагдаж 113.4 тэрбум төгрөг зарцуулсан.
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай чөлөөлж, хөнгөлснөөр 2021 онд нийт аж ахуйн нэгж, даатгуулагч нийтдээ 150.1 тэрбум төгрөгийг өөртөө авч үлдсэн байна. Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан болон сайн дурын даатгуулагчийг НДШ төлөх үүргээс цар тахлын эхэн үед буюу 2020 оны 4 дүгээр сараас 10 сар хүртэл зургаан сарын хугацаанд бүрэн чөлөөлж, 2020 оны 10 дугаар сараас 12 дугаар сарын 31 хүртэл гурван сарын хугацаанд ажилтан, ажил олгогч тус бүр 5 хувь болгож хөнгөлж, 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс 2021 оны 7 дугаар сарын 1-н хүртэл ажилтан, ажил олгогч тус бүр 8.5 хувь болгож тус тус хөнгөлөөд байна.
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу төрөөс хариуцах цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн санхүүжилтэд 612.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс энэ оны эхний хагас байдлаар 561.4 тэрбум төгрөг олгогдоод байна
- ✓ Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг тогтоосон болон вакцинжуулалтын үеэр иргэдэд олгосон дэмжлэг, урамшуулал нь цар тахлын тархалтыг хязгаарлаж, дархлаажуулалтыг богино хугацаанд явуулахад чухал ач холбогдолтой болсон. 2021 оны 4 дүгээр сард цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед Монгол Улсын иргэн бүрд 300 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгоход 1.0 их наяд төгрөг зарцуулав. 2021 оны 5 дугаар сард Ковид-19 цар тахлын эсрэг вакцины эхний тунд хамрагдсан 2.2 сая насанд хүрэгчдэд 50 мянган төгрөгийн урамшуулал олгоход 110 тэрбум төгрөг тус тус зарцуулаад байна.
- ✓ Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд цар тахлын эрсдэлтэй нүүр тулан тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, хил хамгаалах зэрэг тусгай үүргийн байгууллагуудын зардал, бусад төсөвт байгууллагуудын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, бусад зайлшгүй шаардлагатай зардлыг ямар нэгэн хүндрэлгүйгээр бүрэн санхүүжүүлж ирсэн. Харин бусад бүх шатны төсөвт байгууллагуудын бичиг хэрэг, тавилга, эд хогшил, урсгал засвар, гадаад томилолт, татаас, урсгал шилжүүлэг болон бусад бараа үйлчилгээний зардал зэрэг тэвчиж болох зардлыг бүрэн болон хэсэгчлэн зогсоох замаар нийгмийн


Цар тахлын үед төсвийн санхүүжилтийг хэвийн олгож байна.

халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг шийдвэрлэж байна.

Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээрх үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 60.4 хувьтай тэнцэж байсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангаж байгаа юм. Тус харьцаа 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 61.3 хувьтай тэнцэхээр хүлээгдэж байгаа бөгөөд Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 30.9 их наяд төгрөгт хүрэхээр байна. Өрийн бүтцийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 4-өөс харна уу.

Зураг 6. Монгол Улсын Засгийн газрын өр (тэрбум төгрөг)



ХАВСРАЛТ 1. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Макро эдийн засгийн төсөөлөл	х/нэгж	2020 гүйц.	2021.06 сар. гүйц.	2021 ХБГ**	2022 төс.
ДНБ, оны үнээр	их наяд төгрөг	37.0	9.2*	42.1	45.7
Эдийн засгийн өсөлт	хувь	(5.3)	15.7*	6.5	4.6
уул уурхайн	хувь	(9.4)	34.1*	13.7	(6.7)
уул уурхайн бус	хувь	(4.3)	11.1*	4.7	7.7
Инфляц	хувь	2.3	6.6	7.2	6.0
Дундаж ханш	төгрөг	2,813.8	2,849.1	2,861.0	3,070.0
Гадаад худалдааны нийт эргэлт	тэрбум ам.доллар	12.9	7.4	14.5	15.3
Нийт экспорт	тэрбум ам.доллар	7.6	4.1	8.2	8.7
Нийт импорт	тэрбум ам.доллар	5.3	3.3	6.3	6.6
Гадаад худалдааны тэнцэл	тэрбум ам.доллар	2.3	0.8	1.9	2.1

**2021 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл*

***Хүлээгдэж буй гүйцэтгэл*

ХАВСРАЛТ 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (эдийн засгийн ангиллаар, тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2020 Гүйц.Баг (1)	2021 Тод. (2)	2021.06 Гүйц. (3)	2021 ХБГ* (4)
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,444.2	13,731.7	7,106.1	13,731.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	66.2	612.8	259.7	612.8
ИРЭЭДҮЙН ӨВ САН	914.1	1,062.4	417.7	1,062.4
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн (I)	9,463.8	12,056.4	6,428.7	12,056.4
Татварын орлого	8,511.6	10,625.9	5,588.4	10,625.9
Орлогын албан татвар	2,227.3	3,013.3	1,848.2	3,013.3
Нийгмийн даатгалын орлого	1,586.0	1,896.3	994.5	1,896.3
Хөрөнгийн албан татвар	154.9	175.7	94.7	175.7
Онцгой албан татвар	776.9	879.2	396.1	879.2
Тусгай зориулалтын орлого	17.1	15.0	6.5	15.0
адаад үйл ажиллагааны орлого	740.7	935.0	441.4	935.0
Бусад татвар, төлбөр, хураамж	799.7	907.4	461.3	907.4
Татварын бус орлого	952.2	1,430.5	840.3	1,430.5
Нийтлэг татварын бус орлого	785.0	1,279.8	798.6	1,279.8
Хөрөнгийн орлого	1.2	0.4	0.5	0.4
Тусламжийн орлого	166.0	150.3	41.3	150.3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	13,904.3	15,748.3	7,498.2	15,495.5
Нийт зарлага	13,863.2	16,347.2	7,419.3	16,094.4
Урсгал зарлага	10,828.9	12,983.7	6,559.6	12,983.7
Бараа, ажил үйлчилгээний зардал	4,851.2	4,751.4	2,056.3	4,751.4
Хүү	939.2	965.5	420.1	965.5
Татаас	375.0	401.5	202.7	401.5
Урсгал шилжүүлэг	4,663.5	6,865.3	3,880.5	6,865.3
Хөрөнгийн зардал	3,034.2	3,363.5	859.6	3,110.7
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	41.1	-598.9	78.9	-598.9
Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-119.5	-749.9	15.1	-749.9
Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	160.6	151.0	63.8	151.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ (I-II)	-4,440.5	-3,691.8	-1,069.5	-3,439.1
ДНБ-д эзлэх хувь	-12.0%	-8.8%		-8.2%

*Хүлээгдэж буй гүйцэтгэл

ХАВСРАЛТ 3. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хагас жилийн гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэл (төсвийн ерөнхийлөн захирагчаар, сая төгрөг)

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэл 2021.06	Гүйцэтгэл хувь	2021 ХБГ*
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	1	1,066.6	1,066.6	-	0.00%	906.6
Монгол Улсын Их Хурлын дарга	1	3,570.3	3,570.3	-	0.00%	3,034.8
Монгол Улсын Ерөнхий сайд	35	151,128.8	32,830.4	3,791.2	11.55%	27,905.8
Монгол Улсын Шадар сайд	6	32,646.3	22,015.1	7,671.0	34.84%	18,712.8
Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	48	111,547.5	30,963.1	4,330.2	13.98%	26,318.6
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	19	31,998.0	18,045.0	2,989.7	16.57%	15,338.3
Батлан хамгаалахын сайд	5	13,050.0	6,150.0	2,185.9	35.54%	5,227.5
Гадаад харилцааны сайд	2	4,349.4	4,349.4	3,229.3	74.25%	3,697.0
Сангийн сайд	9	289,936.5	88,186.3	10,891.5	12.35%	74,958.4
Хууль зүй, дотоод хэргийн сайд	22	69,098.3	29,157.0	17,056.2	58.50%	24,783.5
Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд	41	73,109.1	24,635.9	2,685.9	10.90%	20,940.5
Барилга, хот байгуулалтын сайд	181	425,047.0	193,290.3	31,645.0	16.37%	164,296.8
Боловсрол, шинжлэх ухааны сайд	354	887,783.2	361,831.5	58,975.3	16.30%	307,556.8
Соёлын сайд	86	548,984.5	92,839.1	14,255.9	15.36%	78,913.3
Зам, тээврийн хөгжлийн сайд	108	659,743.3	233,601.4	51,039.0	21.85%	198,561.2
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	1	3,696.9	1,727.1	610.4	35.34%	1,468.0
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	40	50,365.4	21,122.4	888.2	4.20%	17,954.0
Эрчим хүчний сайд	30	153,017.5	38,052.8	9,184.3	24.14%	32,344.9
Эрүүл мэндийн сайд	96	320,685.5	188,034.7	12,655.2	6.73%	159,829.5
Авлигатай тэмцэх газрын дарга	2	1,150.0	1,150.0	703.7	61.19%	977.5
Шүүхийн ерөнхий зөвлөл	2	4,000.0	4,000.0	-	0.00%	3,400.0
Улсын ерөнхий прокурор	10	43,517.8	20,312.9	3,487.0	17.17%	17,266.0
Монгол Улсын ерөнхий аудитор	1	1,497.3	1,497.3	186.7	12.47%	1,272.7
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	492.5	492.5	-	0.00%	418.6
УЛСЫН ТӨСВИЙН ДҮН	1101	3,881,481.7	1,418,921.0	238,461.4	16.81%	1,206,082.9
КОНЦЕССЫН ДҮН	5	849,759.0	266,268.7	94,100.3	35.34%	226,328.4
НИЙТ	1106	4,731,240.8	1,685,189.7	332,561.7	19.73%	1,432,411.3

*Хүлээгдэж буй гүйцэтгэл

ХАВСРАЛТ 4. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2020 (Гүйц)	2021 (Баг.)	2021.06.30 (Гүйц)
I. Засгийн газрын дотоод өр		1,136.6	3,773.0	1,046.1
1.1	<i>Засгийн газрын дотоод үнэт цаас</i>	1,136.6	3,773.0	1,046.1
II. Засгийн газрын гадаад өр		24,851.4	25,427.8	24,369.3
2.1	<i>Засгийн газрын гадаад үнэт цаас</i>	8,354.0	8,167.0	7,976.2
2.2	<i>Засгийн газрын гадаад зээл</i>	28,120.4	29,565.9	16,393.1
III. Засгийн газрын өрийн баталгаа		1,060.4	963.6	955.3
3.1	<i>Засгийн газрын өрийн баталгаа</i>	1,060.4	963.6	955.3
IV. Барих-шилжүүлэх төрлийн концесс		850.2	754.0	762.5
4.1	<i>Барих-шилжүүлэх төрлийн концесс</i>	850.2	754.0	762.5
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР		27,898.6	30,918.3	27,133.2
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		23,024.3	25,818.4	22,337.8
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		70.0%	70.0%	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		62.3%	61.3%	60.4%